## ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН НЭГТГЭЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 09 дүгээр сарын 15

**Нэг. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд өгсөн санал:**

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хурлын D.PARLIAMENT.MN цахим сүлжээнд байршуулсан бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн байдлаар нийт 466 санал ирүүлсэн байна. Нийт ирүүлсэн саналаас хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой 283 санал, 2 дугаар зүйлтэй холбоотой 183 санал ирүүлснийг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх лавлагаа, мэдээллийг бэлтгэн, нэгдүгээр хавсралтад хавсаргав.




**Хоёр. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үеэр гаргасан санал:**

Хуулийн төслийг боловсруулах явцад олон улсын хэлэлцүүлэг, зөвлөгөөн 1 удаа, холбогдох төрийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 2 удаа тус тус зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэг, зөвлөгөөнд нийт 440 гаруй хүн оролцсон болно. Хэлэлцүүлэг, зөвлөгөөнөөс гарсан нийт саналыг агуулгаар нь нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэн, хоёрдугаар хавсралтад хавсаргав.

**Гурав. Байгууллагуудаас ирүүлсэн санал:**

Хуулийн төсөл боловсруулах явцад нийт 15 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэж, хуулийн төсөлд тусгасан эсэх талаарх дараах лавлагаа, мэдээллийг бэлтгэн, гуравдугаар хавсралтад тус тус хавсаргав.

____oOo___